5.1 Багш нэмэх

Энэ бүлэгт сургалтын үйл ажиллагаа явуулахад оролцож байгаа багшийг сургалтын үүрэг оролцоогоор нь удирдах ажилтан, багш, бусад ажилтан гэж тодорхойлон бүртгэх болон багшийн сургалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг оруулах зааврыг танилцуулна.

Багш нэмэх үйлдлийг хийхээс өмнө системд **дараах нөхцөл** биелсэн байх шаардлагатай.

1. Багш, ажилтныг хүний нөөцийн удирдлагын системд байгууллага дээрээ бүртгэсэн байх, ажил эрхлэлтийг нь баталгаажуулах үйлдэл хийсэн байх
2. Багшийн ажлын байрыг үүсгэхдээ **ажлын байр**ны **ажлын ангилал**ыг зөв сонгож өгөх
3. Боловсролын удирдлага системд тухайн багшийг харьяалуулах сургалт арга зүйн нэгжийг үүсгэсэн байх

Хүний нөөцийн системд багш гэсэн ажлын байран дээр бүртгэгдсэн ажилтныг боловсролын удирдлага систем дээр багшаар ажиллана гэдгийг тодорхойлоход **багш нэмэх** гэсэн үйлдлийг ашиглана.

Багш нэмэх үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтлана. Үүнд:

1. **БУ системийн Багш** үйл ажиллагааг сонгоно.



2. Багш нэмэх цонхны мэдээллийг оруулаад хадгална. /Цонхны баруун дээд хэсэгт байрлах **Багш нэмэх** үйлдлийг дарахад багш бүртгэх дараах цонх нээгдэнэ./



5.2 Багшийн мэдээлэл засварлах

Багшийн мэдээлэл засварлах үйлдлийг хийхээс өмнө системд **дараах нөхцөл** биелсэн байх шаардлагатай.

1. Боловсролын удирдлага системд багш нэмэх үйлдлээр багшийг бүртгэсэн байх
2. Анги бүлэг хэсэгт бүлэг үүсгэхдээ хариуцсан багшийг (АУБ) тодорхойлсон байх
3. Сургалтын орчин хэсэгт хичээлийн байр болон байранд харьяалагдах анги, танхимыг үүсгэсэн байх

Багшийн мэдээлэл оруулах үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтлана. **Үүнд:**

1. **БУ системийн Багш** үйл ажиллагааг сонгоно.
2. Багшийн жагсаалтаас мэдээлэл оруулах багшийн нэрийг сонгоно.
3. Үйлдэл цэснээс **багшийн мэдээлэл** үйлдлийг дарна эсвэл жагсаалтаас багшийн нэр дээр дарна.
4. Багштай холбоотой бүлэг мэдээллийг оруулаад хадгална.

Багшийн мэдээлэл оруулах үйлдлийг хийх алхамчилсан дараалал дараах байдалтай байна.

Үйл ажиллагааны жагсаалтаас **Багш**-ийг сонгоход дараах цонх нээгдэнэ.

Цонхны баруун дээд хэсэгт байрлах үйлдэл цэснээс **Багшийн мэдээлэл** үйлдлийг дарах эсвэл **багшийн нэр** дээр дарахад багшийн мэдээлэл харуулсан цонх нээгдсэний **мэдээлэл засах** товчийг дарахад дараах цонх дуудагдана.



Үндсэн мэдээлэл:

Овог	Багшийн үндсэн мэдээллээс автоматаар татагдана. Засах боломжгүй байна.
Нэр	Багшийн үндсэн мэдээллээс автоматаар татагдана. Засах боломжгүй байна.
Регистрийн дугаар	Багшийн үндсэн мэдээллээс автоматаар татагдана. Засах боломжгүй байна.
Албан тушаал	Хүний нөөцийн системд ажилд авсан ажлын байрны нэр автоматаар татагдана. Засах боломжгүй байна. Хэрэв албан тушаал буруу бол хүний нөөцийн системийн ажилтны жагсаалт хэсэгт албан ажил эрхлэлт руу орж засах үйлдлээр засна.
Багшийн төрөл	**Багш нэмэх** үйлдлээр багш нэмэх үед сонгосон багшийн төрөл харагдана. Засах боломжтой байна. Хэрэв засах бол тухайн багш ямар төрлийн багш гэдгийг сонгоно. (Бага ангийн үндсэн багш, , мэргэжлийн багш гэх мэт) Сургуулийн хувьд багшийн хичээлийн дийлэнхийг аль боловсролын түвшинд зааж байгаагаас хамаарч багшийн төрлийг сонгоно. **Анхаарах нь: Мэргэжлийн багш** гэсэн нэр томьёо нь ихэвчлэн **ХБК-ийн** мэргэжлийн багш бүртгэхэд ашиглана. ЕБС-ийн хувьд бага, дунд, ахлах (үндсэн, цагийн) аль ангид дийлэнх хичээлийг орж байгаагаас шалтгаалж багшийн төрлийг сонгоно. Ингэснээр багштай холбоотой тайлан мэдээ зөв гарна.
Салбар, бүрэлдэхүүн	Багш нэмэх үйлдлээр багшийг нэмэх үед сонгосон салбар, бүрэлдэхүүн харагдана. Засах боломжтой байна. Сургалтын байгууллага нь салбар, бүрэлдэхүүнгүй бол салбар бүрэлдэхүүн нь сургалтын байгууллага байна.
САЗНэгж	Багш нэмэх үйлдлээр багшийг нэмэх үед сонгосон сургалт, аргазүйн нэгж харагдана. Засах боломжтой байна.
Удирдагч багш	Бүртгэж байгаа багш нь анги, бүлэг удирдсан, суралцагчид зөвлөх багшаар (их, дээд сургуульд ихэвчлэ

5.3 Багшаас хасах

Боловсролын удирдлага систем дээр багш гэж тодорхойлж нэмсэн багш нь багшаас болих, сургуулиас гарсан бол багшаас хасах үйлдлийг хийхэд ашиглана.

Багшаас хасах үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтлана. Үүнд:

1. БУ системийн Багш үйл ажиллагааг сонгоно.



2. Багшийн жагсаалтаас багшаас хасах багшийн нэрийг сонгоно.

3. Үйлдэл цэснээс **Багш, ажилтны мэдээлэл устгах** үйлдлийг дарна.

Багшаас хасах үйлдлийг хийх алхамчилсан дараалал дараах байдалтай байна.

Үйл ажиллагааны жагсаалтаас **Багш**-ийг сонгоход дараах цонх нээгдэнэ.

Үйлдлийн арын сум дээр дарж **Багш, ажилтны мэдээлэл устгах** үйлдлийг хийхэд хэрвээ тухайн багш дээр нэмэлт мэдээлэл бүртгэлтэй бол дараах анхааруулгыг харуулна.

	Багшийн нэмэлт мэдээллийг устгасны дараа багшийг хасах боломжтой. Хариуцсан анги, бүлэг, хариуцсан анги, танхим, заадаг хичээл зэргийн бүртгэлийг хассаны дараа багшийг устгана.
	Тийм товчийг дарснаар багшаас хасагдана.

5.4 Хариуцсан анги бүлгийн мэдээлэл

Багшийн хариуцсан анги, бүлгийн мэдээлэл оруулах үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтлана. Үүнд:

1. **БУ системийн Багш** үйл ажиллагааг сонгоно.
2. Багшийн жагсаалтаас хариуцсан анги, бүлгийн мэдээлэл оруулах багшийн нэрийг сонгоно.
3. Үйлдэл цэснээс **багшийн мэдээлэл** үйлдлийг дарна эсвэл жагсаалтаас багшийн нэр дээр дарна.
4. Багшийн мэдээлэл цонхноос Хариуцсан анги, бүлэг цэс рүү орно.
5. Мэдээлэл засах товч дарна.
6. Бүлэг нэмэх товч дарна.



Анги бүлэг	**Анги бүлэг** хэсэгт бүлэг үүсгэх үед тухайн багшийг **хариуцсан багш (АУБ)** хэсэгт тодорхойлсон бол багшийн мэдээллийн хариуцсан анги, бүлэг мэдээллийн хэсэгт хариуцсан ангийг шууд харуулна. Жич: Ахлах бүлгийн АУБ-ийг шууд харуулна.
Хариуцсан үүрэг	**Анги бүлэг** хэсэгт бүлэг үүсгэх үед тухайн багшийг **хариуцсан багш** хэсэгт тодорхойлохдоо хариуцсан үүргийг тодорхойлсон бол **хариуцсан үүрэг** талбарт тухайн үүрэг харагдана. Жишээ нь: анги удирдсан багш, туслах багш гэх мэт.
Эхлэх огноо	Анги хариуцаж эхэлсэн болон эхлэх огноог оруулж өгнө.

5.5 Хариуцсан анги танхимийн мэдээлэл

Багшийн хариуцсан анги, танхимийн мэдээлэл оруулах үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтлана. **Үүнд**:

1. **БУ системийн Багш** үйл ажиллагааг сонгоно.
2. Багшийн жагсаалтаас хариуцсан анги, танхимийн мэдээлэл оруулах багшийн нэрийг сонгоно.
3. Үйлдэл цэснээс **багшийн мэдээлэл** үйлдлийг дарна эсвэл жагсаалтаас багшийн нэр дээр дарна.
4. Багшийн мэдээлэл цонхноос Хариуцсан анги, танхим цэс рүү орно.

5. Мэдээлэл засах товч дарна.
6. Анги, танхим нэмэх товч дарна.



Анги танхим	Хэрэв багш ямар нэг анги, танхим хариуцдаг бол энэ талбарт тухайн багшийн хариуцдаг анги, танхимын нэрийг бичихэд системд үүсгэсэн нийт анги танхимын жагсаалт харагдана. Жагсаалтаас сонгоно. Хэрэв сонгохыг хүссэн анги танхим жагсаалтад байхгүй бол **БУ** системийн **сургалтын орчин** хэсгийн **өрөө** табын **шинэ өрөө** үйлдлээр анги, танхимыг нэмж өгнө.
Төрөл	**БУ** системийн **сургалтын орчин** хэсгийн **өрөө** табын **шинэ өрөө** үйлдлээр тухайн анги, танхимыг үүсгэх үед бүртгэсэн өрөөний төрөл энэ талбарт автоматаар бөглөгдсөн байна. Засах болможгүй байна. Хэрэв өрөөний төрөл буруу бол **БУ** системийн **сургалтын орчин** хэсгийн **өрөө** табын өрөөний жагсаалтаас өрөөг сонгож **засах** үйлдлээр орж **төрөл** талбарыг засна.
Тоот	**БУ** системийн **сургалтын орчин** хэсгийн **өрөө** табын **шинэ өрөө** үйлдлээр тухайн анги, танхимыг үүсгэх үед бүртгэсэн өрөөний тоот энэ талбарт автоматаар бөглөгдсөн байна. Засах боломжгүй байна. Хэрэв өрөөний тоот буруу бол **БУ** системийн **сургалтын орчин** хэсгийн **өрөө** табын өрөөний жагсаалтаас өрөөг сонгож **засах** үйлдлээр орж **тоот** талбарыг засна.
Байр	**БУ** системийн **сургалтын орчин** хэсгийн **өрөө** табын **шинэ өрөө** үйлдлээр тухайн анги, танхимыг үүсгэх үед бүртгэсэн өрөөний тоот энэ талбарт автоматаар бөглөгдсөн байна. Засах боломжгүй байна. Хэрэв өрөөний тоот буруу бол **БУ** системийн **сургалтын орчин** хэсгийн **өрөө** табын өрөөний жагсаалтаас өрөөг сонгож **засах** үйлдлээр орж **тоот** талбарыг засна.
Хариуцсан %	Анги, танхим хариуцалтын хувийг оруулна. Жишээ нь: Хэрэв нэг ангийг 2 анги даасан багш хариуцдаг бол 50% гэж оруулна.
Анги, танхим нэмэх	Энэ үйлдлийг дарснаар багшийн хариуцсан анги, танхимыг тодорхойлоход зориулсан мөр нэмэгдэнэ. Багш олон анги, танхим хариуцдаг бол анги, танхим нэмэх үйлдлийг дахин дарж нэмж тодорхойлох

	боломжтой.